



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

Байгууллагад чанарын менежментийн
тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Захиргаа, удирдлагын газрын дарга

Ажлын хэсгийн дэд ахлагч: Чанарын хяналтын газрын дарга

Гишүүд: Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар,
Шинэ эм, эмнэлзүйн судалгааны асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

Эм хангамжийн газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн
хангамж, хүртээмж, ложистикийн асуудал
хариуцсан ахлах мэргэжилтэн

Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны
газар, Эмийн чанар, аюулгүй байдлын тандалт
судалгааны асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар, Эмнэлгийн
тоног төхөөрөмжийн зохицуулалт, шалгалт
тохируулгын асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Чанарын хяналтын газар, Эм үйлдвэрлэлийн
хэлтэс, Эм үйлдвэрлэлийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн

142022 01050

Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар,
Эмийн бүртгэлийн хэлтэс, Эмийн бүртгэлийн
зохицуулалтын асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Чанарын хяналтын газрыг ахлах, Эм,
биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч

Захиргаа, удирдлагын газар, Дотоод аудит,
үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Захиргаа, удирдлагын газар, Маркетинг,
төлөвлөгөө, тайлан хариуцсан ажилтан

2.Байгууллагад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын
төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийн тайланг 2022 оны 12 дугаар
сарын 31-ний өдрийн дотор Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, ажиллахыг
ажлын хэсэг (Л.Намхайноров)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт,
зохицуулалтын газрын даргын 2021 оны А/253 дугаар тушаалыг хүчингүй болсонд
тооцсугай.

ДЭД ДАРГА, ДАРГЫН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.УРАНЗАЯА